



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 4/68

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Аврах тусгай анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч наарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (онцгой байдлын хурандаа Д.Дарь Сүхбаатар)-д даалгасугай.

ДАРГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХУРАНДАА

Т.ДУЛАМДОРЖ



Онцгой байдлын өрөнхий газрын даргын
2013 оны 06 дүгээр сарын 18.ны өдрийн
1/468 дугаар тушаалын хавсралт

ТУСГАЙ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БҮЛГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цацраг, хими, биологийн гаралтай ослын голомт, мөн террорист халдлагын үед хүн, мал, амьтан хордох, байгаль орчинд их хэмжээний бохирдол үүсэх үед тархалтыг хязгаарлан зогсоох зорилгоор тусгай цэвэрлэгээ хийж хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс нь цацраг, хими, биологийн гаралтай ослын үед ажиллах "Тусгай цэвэрлэгээний бүлэг"-ийг томилгоожуулсан байна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "Химийн осол" гэж химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны горим зөрчигдөх, технологийн явцад эвдрэл гарах, санамсар болгоомжгүй байдлаар алдагдах зэргээс шалтгаалан хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг хэлнэ.

2.1.2. "Цацрагийн осол" гэж цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, хадгалах, ашиглах, булшлах явцад технологийн горим зөрчигдөх гэмтэл гарах, орчинд их хэмжээгээр тархах зэргээс шалтгаалан хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг хэлнэ.

2.1.3. "Биологийн гаралтай хордолт" гэж өвчин үүсгэгчээр хүн, мал, амьтан өвчлөх, халдвялах, хүрээлэн буй орчин бохирдох тохиолдлыг хэлнэ.

2.1.4. "Ахуйн осол" гэдэг нь ахуйн хэрэглээнд цацраг, хими, биологийн гаралтай хорт бодис алдагдахад тухайн орчинд байх хүн, мал, амьтан, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл хордох, бохирдох тохиолдлыг хэлнэ.

2.1.5. "Орчны осол" гэдэг нь тодорхой хүрээний газар орон /барилга, байгууламж, үйлдвэр гэх мэт/-д цацраг, хими, биологийн гаралтай хорт бодис алдагдаж хүрээлэн буй орчинд байх техник, тоног төхөөрөмж бохирдож хүн, мал, амьтан нэrvэгдэх тохиолдлыг хэлнэ.

2.1.6. “Нийтийг хамарсан осол” гэдэг нь тодорхой хүрээний газар оронд цацраг, хими, биологийн гаралтай хорт бодис алдагдаж, түүнээс гадагш тэлж ойролцоо хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчин хордох, бохирдох, нэрвэгдэх тохиолдлыг хэлнэ.

2.1.7. “Ослын голомт” гэдэг нь цацраг, хими, биологийн гаралтай хорт бодис тухайн газар оронд, тодорхой хугацаанд тархаж, агаарт хуримтлагдан хүний эрүүл мэнд, байгаль орчинд тодорхой хугацаанд сөрөг нөлөө үүсгэсэн бүсийг хэлнэ.

2.1.8. “Хор уршиг” гэдэг нь хүн, мал, амьтан, аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, хүрээлэн буй орчинд үзүүлэх хорт бодисын нөлөөлөх үйлчлэлийг хэлнэ.

2.1.9. “Тусгай цэвэрлэгээ” гэж цацраг, хими, биологийн гаралтай ослоос үүдэлтэй хордсон хүн, мал, амьтанд эрүүл ахуйн цэвэрлэгээ хийх, байгаль орчин, барилга байгууламж, багаж, техник хэрэгслийн бохирдлыг арилгах зорилгоор идэвхжил супруулалт, саармагжуулалт, хоргүйжүүлэлт, ариутгал халдвартгүйжүүлэлт хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахыг хэлнэ.

2.1.10. “Тусгай цэвэрлэгээний бүлэг” гэж тусгай зориулалтын техник, хамгаалах хувцас, багаж хэрэгслээр хангагдан тусгай цэвэрлэгээ хийх ажиллагаанд мэргэшсэн аврагч-химич нарын бүрэлдэхүүнтэй бүлгийг хэлнэ.

2.1.11. “Тусгай цэвэрлэгээний бүлгийн дарга” гэдэг нь бүлгийг удирдан зохион байгуулах чадвартай, тусгай цэвэрлэгээний тоног төхөөрөмж, техник, хэрэгсэл болон хорт бодистой ажиллах чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн дадлага туршлагатай албан хаагчийг хэлнэ.

2.1.12. “Аврагч-химичин” гэдэг нь цацрагийн ослын үед идэвхжил супруулалт хийх, химиин хорт болон аюултай бодисын техник, технологийн холбогдолтой ослын үед саармагжуулалт, хоргүйжүүлэлт хийх, биологийн гаралтай хордolt тохиолдсон үед ариутгал халдвартгүйжүүлэлт хийх ажиллагаанд бэлтгэгдэж мэргэшсэн албан хаагчийг хэлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Цацраг, хими, биологийн гаралтай хорт бодисын ослын хор уршийг арилгах үйл ажиллагааны зохион байгуулалт нь түүний нэр төрөл, шинж чанар, хамрах хүрээ, хор уршгаас шууд хамаарч харилцан адилгүй байна.

3.2. Ахуйн ослын хор уршгийг арилгах ажиллагааг аж, ахуйн нэгж, байгууллагын аврах баг зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн бүлэг ажиллана.

3.3. Орчны ослын хор уршгийг арилгах ажиллагаанд тухайн аж, ахуйн нэгж, байгууллагын хүч хэрэгсэл, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Тусгай цэвэрлэгээний бүлэг ажиллана.

3.4. Нийтийг хамарсан ослын хор уршгийг арилгах ажиллагаанд тухайн аж, ахуйн нэгж, байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Тусгай цэвэрлэгээний бүлэг, гамшигаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгсэл, зэвсэгт хүчний тусгай зориулалтын анги, салбарыг оролцуулна.

3.5. Тусгай цэвэрлэгээний бүлэг үүрэг гүйцэтгэх үед харьяалах салбар, нэгжийн дарга хяналт тавьж ажиллана.

3.6. Цацраг, хими, биологийн гаралтай ослыг цар хүрээнээс нь хамаарч шаардагдах хүч хэрэгслээр нэмэгдүүлэх асуудлыг харьяалах аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцан зохион байгуулна.

3.7. Ослын хор уршиг, хамрах хүрээ нь аймаг, нийслэлийн хүч хэрэгслийн чадавхиас давсан тохиолдолд Аврах тусгай ангийн мэргэжлийн бүлгийг хүч нэмэгдүүлэн ажиллуулж болно.

Дөрөв. Тусгай цэвэрлэгээний бүлгийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ,
бие бүрэлдэхүүний үүрэг

4.1. Бүлгийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.1. Цацраг, хими, биологийн гаралтай хорт бодисын осол болон хордолтын шалтгааныг илрүүлэх;

4.1.2. Тандалт, судалгаа хийх;

4.1.3. Цацраг, хими, биологийн гаралтай хорт бодисын тархалтыг зогсоох;

4.1.4. Идэвхжил сулруулалт, хоргүйжүүлэлт, саармагжуулалт, ариутгал халдвартгүйжүүлэлт хийх;

4.1.5. Ашиглалт, хадгалалтын шаардлага хангахгүй, нэр төрөл, шинж чанар нь тодорхой бус цацраг, хими, биологийн гаралтай хорт бодистой ажиллах тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулах.

4.2. Бүлгийн даргын үүрэг

4.2.1. Тусгай цэвэрлэгээнд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдыг шууд захирах дарга бөгөөд дараах үүрэгтэй:

4.2.1.1. Ослын хор уршгийг арилгах төлөвлөгөө боловсруулах, ажиллагаанд шаардагдах төсвийг тооцоолох “Цацраг, хими, биологийн ослын хяналтын хуудас”-ыг хөтлөх; (2 дугаар хавсралт)

4.2.1.2. Ослын голомтод үүссэн цагийн байдалтай уялдуулж шийдвэрийг цаг тухайд нь гаргаж бүлэгт шаардлагатай хүч, хэрэгслээр хангах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;

4.2.1.3. Ослын голомтод үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг тодотгож тэдэнд үүссэн цагийн байдлын талаар тодорхой мэдээлж, аюулгүйн зааварчилгаа өгөх;

4.2.1.4. Бүлгийн бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хангуулах, ажиллагааны явцад хяналт тавих;

4.2.1.5. Цагийн байдлыг үнэлэх, хордолтын бүсийн хилийг тодорхойлох;

4.2.1.6. Шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллага хэргийн газарт үзлэг хийх боломжийг хангах ажлыг зохион байгуулах;

4.2.1.7. Цацраг, хими, биологийн гаралтай хорт бодисын осолд нэрвэгдсэн хүнийг илрүүлж, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.1.8. Дээж авах ажлыг зохион байгуулж, лабораторийн шинжилгээнд илгээх;

4.2.1.9. Ослын шалтгаан, нөхцөл байдал болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, дүгнэлтийг ахлах болон нэгжийн даргад танилцуулах, мэдээллээр хангах.

4.3. Аврагч-химичийн үүрэг

4.3.1. Ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, дагалдах хэрэгслийн эд анги, зориулалт, ашиглалтыг зааврын дагуу хэрэглэх мэдлэг чадвартай байх, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;

4.3.2. Хүн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах;

4.3.3. Ослын голомтод тандалт, судалгаа, тусгай цэвэрлэгээ хийх ажиллагааг бүлгийн даргын үүрэг, даалгавар, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэх;

4.3.4. Тусгай цэвэрлэгээний явцтай холбоотой алдаа, зөрчил дутагдлын талаар ахлах даргад яаралтай мэдэгдэх;

4.3.5. Тусгай цэвэрлэгээний багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжтэй харьцах хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөж, сахилга, ёс зүйн зөрчил гаргахгүй байх.

4.4. Эмчийн үүрэг

4.4.1. Ослын голомтод ажиллагсад болон нэрвэгдэгсдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх; (3 дугаар хавсралт)

4.4.2. Шаардлагатай тохиолдолд нэрвэгдэгсдийг тээвэрлэж эмнэлгийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулах.

4.5. Жолооч-холбоочны үүрэг

4.5.1. Тусгай цэвэрлэгээний бүлгийн хүч хэрэгслийг ослын голомтод шуурхай хүргэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.5.2. Ослын голомтод авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг ахлах даргад тухай бүрт шуурхай хүргэж, холбоог зохион байгуулах.

Тав. Аюулгүйн арга хэмжээ

5.1. Тусгай цэвэрлэгээний бүлэг нь тусгай зориулалтын техник, багаж хэрэгсэл, хамгаалах хувцсаар хангагдсан байна. (1 дүгээр хавсралт)

5.2. Хүн нэг бүрийн хамгаалах хувцас, багаж хэрэгсэл ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд тусгай цэвэрлэгээ хийхийг хориглоно.

5.3. Тусгай цэвэрлэгээний бүлгийн албан хаагч нь аюулгүй байдал хангагдаагүй тохиолдолд үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

5.4. Тусгай цэвэрлэгээний бүлгийн албан хаагчид жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах бөгөөд ослын голомтод үүрэг гүйцэтгэсний дараа хордолтын зэргээс шалтгаалан эмнэлгийн үзлэгт тухай бүр хамрагдана.

Зургаа. Томилолт, урамшуулал, зардал

6.1. Тусгай цэвэрлэгээний бүлгийн томилолт, урамшууллын зардлыг “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын 2011 оны 47/186 дугаар тушаалаар баталсан “Аюулт үзэгдэл, төхникийн холбогдолтой ослын үед аврах ажиллагаа явуулсан онцгой

байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч болон иргэнд урамшуулал олгох журам"-ын 2.3, 3.1-т заасны дагуу олгоно.

6.2. Террорист халдлагад хортой бодис ашиглах, эзэнгүй хог хаягдлыг саармагжуулах, хоргүйжүүлэх, устгах ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.3. Тусгай цэвэрлэгээ хийх ажиллагаанд шаардагдах зардлыг "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, "Химиин хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг тус тус үндэслэн холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. "Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам"-ын хэрэгжилтэд Онцгой байдлын өрөнхий газрын гамшгийн асуудал эрхэлсэн дэд дарга хяналт тавьж ажиллана.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----оОо-----

“Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам”-ын 1 дүгээр хавсралт

ТУСГАЙ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БҮЛГИЙН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Хүч хэрэгслийн нэр	Тоо	Үүрэг
Бүлгийн бие бүрэлдэхүүн:			
1.	Бүлгийн дарга	1	Бүлгийн бие бүрэлдэхүүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, тэмдэглэл хөтлөх.
2.	Аврагч-химич	5	Тандалт, судалгаа, тусгай цэвэрлэгээг гардаж гүйцэтгэх.
3.	Эмч	1	Цацраг, хими, биологийн ослын үед хордсон, бохирдсон, гэмтсэн албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед 2, 3 дугаар шатлалын эмнэлэгт хүргэх.
4.	Жолооч-холбоочин	1	-Бүлгийн бие бүрэлдэхүүнийг шуурхай ослын бүсэд хүргэх, үйл ажиллагаанд туслах үүрэг гүйцэтгэх. -Холбоо мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцах. -Ослын голомтод авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг ахлах даргад цаг тухайд нь шуурхай хүргэж, холбоог зохион байгуулах.
Техник, багаж, хэрэгсэл			
1.	Тусгай зориулалтын автомашин	1 нэгж	Ослын голомтод бие бүрэлдэхүүнийг шуурхай хүргэж, техник, багаж хэрэгслийг тээвэрлэх зориулалттай.
2.	Тандалтын багаж, хэрэгсэл (илрүүлэгч), (илрүүлэгч-хэмжигч)	2 иж	Гадна болон дотор орчны агаар дахь хорт бодисыг тодорхойлох, дээж авахад ашиглагдана. Салхины чиглэл, тодорхойлоход хэрэглэгдэнэ.
3.	Хэт богино долгионы радио станц	4	Холбоо мэдээллээр хангахад ашиглана.

4.	Тусгай цэвэрлэгээний бодис, уусмал /хорт бодисын нэр, төрлөөс шалтгаална/	Бодис уусмалын иж бүрдэл	Цацраг, хими, биологийн гаралтай бодисын хордолтод тусгай цэвэрлэгээ хийхэд зориулагдсан уусмал.
5.	Дээж авах багаж хэрэгсэл, сав, баглаа	5	Дээжийг зориулалтын битүүмжлэл сайтай саванд хийж шинжилгээний лабораторид хүргүүлэхэд зориулагдсан 50 граммаас 5 литрийн багтаамжтай сав.
7.	Хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгсэл	B, C зэрэглэлийн хувцас тус бүр 8 ширхэг Нийт-16 ширхэг	Бие бүрэлдэхүүнийг цацраг, хими, биологийн гаралтай хорт бодисоос хамгаалахад зориулагдсан тусгай зориулалтын баг, хамгаалах хувцас.
Шаардлагатай тохиолдолд ажиллах тусгай цэвэрлэгээний техник хэрэгсэл			
1.	Ариутгалын шүршүүрийн төхөөрөмж (ДДА-3Б)	1 нэгж	Бие бүрэлдэхүүн болон хамгаалах хувцас, техник хэрэгсэлдээрүүл ахуйн тусгай цэвэрлэгээ хийнэ.
2.	Авто юлэн хуваарилагч станц (APC-14У)	1 нэгж	Алдагдаж байгаа цацраг, хими, биологийн гаралтай хорт бодис болон бохирдсон гадаргууд тусгай цэвэрлэгээ хийнэ.

-----оОо-----

“Тусгай Цэвэрлэгээний булгийн
ажиллах журам”-ын 2 дугаар хавсралт

ЦАЦРАГ, ХИМИИ, БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ ОСТЬН ХЯЧАТПЫНХУУДАС

№/№	Үүссэн цагийн байдлын үнэлгээ	Томилгоот булгийн бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл			
		д/д	Бүрэлдэхүүн	Цол / нэр	Утасны дугаар:
1.	Осол болсон анхны цаг	1.	Булгийн дарга	
2.	Дуудлага хүлээн авсан хугацаа	2.	Эмч	1..... 2..... 3.....	
3.	Ослын голомтод очсон хугацаа	3.	Аврагч-химичин	1..... 2..... 3.....	
4.	Мэдээлэл өгсөн иргэн ААНБ-ын талаарх мэдээлэл, утасны дугаар, осол гарсан шалтгаан	4.	Жолооч-холбоочин	
5.	Цагийн байдлыг үнэлж таргасан шийдвэр	5.			
6.	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	6.	-Техник, хэрэгсэл -Ажлын багтаамж -Нөөц	1..... 2..... 3..... 4.....	
7.	Ослын голомтод ажилласан хугацаа	7.			
8.	Эзлж, амрант зохион байгуулсан хугацаа	8.			
10.	Ажиллагаа дууссан хугацаа	10.	Алдагдсан бодис /Цацрайчин үүсгүүр/ биологийн гаралтай хорт бодисын нэр, төрөл, хэмжээ	1..... 2..... 3..... 4.....	
11.	Алдагдсан бодис /Цацрайчин үүсгүүр/ биологийн гаралтай хорт бодисын осолд өтөсөн хүний тоо, нэр	11.	Цаашид анхаарах эзүйлс	1..... 2..... 3.....	

Тэмдэлэл хөтөлсөн.....Цол/нэр

“Тусгай цэвэрлэгээний бүлгийн
ажиллах журам”-ын 3 дугаар хавсралт

АЛБАН ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУДАС

....он....сар...өдөр

д/д	Овог:.....	Нэр:.....
1.	Нас:.....	Хүйс:.....
2.	Албан тушаал:	
3.	Илэрсэн хугацаа болон юунаас болж хордсон талаарх мэдээлэл:	
4.	Одоо илэрч байгаа зовиур:	
5.	Биеийн байдал:	
6.	Шинжилгээний дүгнэлт:	
7.	Онош:	
8.	Дүгнэлт гаргасан эмнэлгийн нэр, харьяалал:	
9.	Эмчийн дүгнэлт:	

Эмчийн гарын үсэг..... тэмдэг